

БАТЛАВ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН

ӨСВӨР НАСНЫХНЫ "АЗ ЖАРГАЛ ТӨВ"-ИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

Зорилго: Өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл өгөх, тусlamж үйлчилгээний хүrtээмж, чанарыг сайжруулах зорилгоор төрийн бус байгууллагын хамтын ажиллагаанд түшиглэсэн өсвөр үе, залуучуудад зэлтэй, сэтгэлд нийцсэн үйл ажиллагаа явуулах таатай орчин бүрдүүлэх

Нийт төсөв: Орон нутгийн төсөв 37.8 сая төгрөг


Хугацаа: 2024 он


Гүйцэтгэх ажил:

№	Гүйцэтгэх ажил	Тавигдах шаардлага
1.	Байр ашиглалтын тогтмол зардал	Нийт төсвийн 20 хувь хүrtэл
2.	Ерөнхий шаардлага	<p>Ажлын өдрүүдэд 08:00-17:00 цаг хүrtэл тогтмол ажиллах</p> <p>Эмч/бага эмч, нийгмийн ажилтан болон орон тооны бус сэтгэлзүйч/ зөвлөхийн бүрэлдэхүүнээр 2-оос доошгүй хүн ажиллана.</p> <p>Төвийн нийгмийн ажилтнаар өсвөр үеийн чиглэлээр мэргэшсэн нийгмийн ажилтан, сувилагч, бага эмч ажиллаж болно.</p> <p>Өөрийн үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн талаар мэдээллийн сан үүсгэн, баяжилтыг тогтмол хийнэ. Мөн эрүүл мэндийн хэрэгцээний байдалд тогтмол үнэлгээ судалгаа хийж шаардлагатай үйл ажиллагааг цаг алдалгүй зохион байгуулах</p> <p>Эрүүл ахуй, халдварт хамгааллын дэглэмийг чанд баримтлан ажиллах</p>
3.	Үйл ажиллагааны чиглэл	<p>Өсвөр үеийнхэн болон тэдний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч наарт сургалт, сурталчилгаа зохион байгуулах</p> <p>Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн асуудлаар боловсрол, нийгмийн хамгааллын болон бусад салбарынхантай хамтран ажиллан, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах</p> <p>Өрх, сумын эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, коллежийн эмч, өсвөр үеийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай нягт хамтран ажиллах</p> <p>Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн чиглэлээр тулгамдаж байгаа асуудлын талаар судалгаа хийх</p> <p>Үе тэнгийн сургагч бэлтгэн, чадавхижуулах</p> <p>Жилийн хугацаанд 3000-аас доошгүй өсвөр үе залуучуудад бэлгийн цогц боловсрол болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх</p> <p>"Аз жаргал төв"-ийн цахим хуудсанд сүүлийн үеийн нотолгоонд суурилсан өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох, идэвхитэй хөтлөн ажиллуулах</p>
4.	Гүйцэтгэгчид тавигдах шаардлага	<p>Аз жаргал төвийн үйл ажиллагааг дараах талууд хамтран хэрэгжүүлнэ.</p> <p>Аймгийн Эрүүл мэндийн газар</p> <p>Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар</p> <p>Боловсрол, шинжлэх ухааны газар</p>

Бусийн оношилгоо эмчилгээний төв
Өсвөр үеийнхэн, залуучуудын эрх ашиг, хүний эрхийг дээдлэх
Жендерийн тэгш байдлыг хангаж ажиллах
Хувийн нууцыг хадгалах
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад ээлтэй байх
Үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх
Өсвөр үеийнхэн, залуучуудын оролцоонд тулгуурлах
Ажил гүйцэтгэх гэрээнд заасан хугацаанд ажлаа бүрэн гүйцэтгэх чадвартай байх
Ажиллах хүний нөөцөөр хангагдсан байх
Аз жаргал төвийн үйл ажиллагааны хэрэгжилт, үйл явцыг үнэн бодитой, баримттай тайлагнадаг байх

БОЛОВСРУУЛСАН
АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА  Ч.ОЮУНАА

ТАНИЛЦСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН
БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Э.ЭРДЭНЭБИЛЭГ

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА  М.НЯМСҮРЭН